



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 05 сарын 11 өдөр

Дугаар А/26

Чойр

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3.2, Сангийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 282 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 11.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн “Аймгийн Засаг даргын Тамгын газарт автомашин худалдан авах” ажлыг ашиглалтад хүлээн авах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:

Н.Батцэцэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Нарийн бичгийн дарга:

Г.Энххишиг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн)

Гишүүд:

Х.Алтанцэцэг (Орон нутгийн өмчийн газрын Орон нутгийн өмч хариуцсан ахлах мэргэжилтэн)

В.Баярсайхан (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийтлэг үйлчилгээний албаны менежер)

Л.Батзаяат (Аймгийн Засаг даргын Тамгын газрын жолооч)

2. Тус ажлыг техникийн тодорхойлолтод заагдсан тоо хэмжээ, үзүүлэлтийн дагуу шаардлага хангуулан холбогдох хууль тогтоомжийн дагуу хүлээн авч үр дүнг 2021 оны 05 дугаар сарын 16-ны өдөр танилцуулахыг ажлын хэсгийн дарга (Н.Батцэцэг)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Д.СОДНОМ

